



**ХЭНТИЙ АЙМГИЙН
ЦЭНХЭРМАНДАЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ**

2026 оны 03 сарын 25 өдөр

Дугаар 5/04

Модот

**И.Найманцэцэгт жирэмсний болон
амаржсаны амралт олгох тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь заалт, Төрийн албаны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.4 дэх заалт, Хөдөлмөрийн тухай хуулийн 137 дугаар зүйлийн 137.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Тус сумын Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын асуудал хариуцсан мэргэжилтэн Ичинхорлоогийн Найманцэцэгийн 2026 оны 03 дугаар сарын 25-ний өдөр гаргасан өргөдлийг үндэслэн 2026 оны 03 дугаар сарын 25-ний өдрөөс эхлэн жирэмсний болон амаржсаны амралтын чөлөө олгосугай.

2.Нийгмийн бодлогын асуудал хариуцсан мэргэжилтэн И.Найманцэцэгийн ажлыг хүлээлцэх ажлын хэсгийн дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай. Үүнд:

Ажлын хэсгийн ахлагч Д.Өсөхгэрэл -Мал аж ахуйн үйлдвэрлэлийн төлөвлөлт, менежмент, малын үржил бүртгэлийн асуудал хариуцсан мэргэжилтэн


Нарийн бичгийн дарга З.Энхбямба - Улсын бүртгэгч

Гишүүд

Е.Нармандах - Архив, бичиг хэргийн эрхлэгч

3.И.Найманцэцэгийн холбогдох баримт бичгийн үндэслэн зохих журмын дагуу жирэмсний болон амаржсаны тэтгэмжийн бодож олгох, нийгмийн даатгалын шимтгэлийн Засгийн газраас тогтоосон хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс ажил олгогчийн төлбөл зохих хувиар сар бүр тооцож даатгалын зохих санд төлөхийг Засаг даргын Тамгын газрын Нягтлан бодогч (Б.Буяндэлгэр)-т зөвшөөрсүгэй.

ДАРГА



Ү.ИЧИНХОРЛОО